МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨ ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛДСЭН БАТЛАМЖИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

*/2009 оны жилийн эцсийн байдлаар/*

2010-03-15. Орхон аймаг.

| **д/д** | **Заалтын дугаар** | **Биелэлтийн хувь** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **100** | **90** | **70** | **50** | **30** | **10** | **0** | **Хугацаа болоогүй.** |
| 1. | 1 | | + | | | | | | |
| 2. | 2 | | + | | | | | | |
| 3. | 3 | | + | | | | | | |
| 4. | 4 | | + | | | | | | |
| 5. | 5 | | + | | | | | | |
| 6. | 6 | | + | | | | | | |
| 7. | 7 | | + | | | | | | |
| 8. | 8 | + | | | | | | | |
| 9. | 9 | + | | | | | | | |
| | **Нийт** | **2** | **7** | | | | | | |

***Гүйцэтгэлийн хувь92,2 %***
***Биелэлтийн үнэлгээний оноо 4,6***

***МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨ ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛДСЭН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ***

*/2009 оны жилийн эцсийн байдлаар/*

2010-03-10. Эрдэнэт хот.

| д/д | Батламжийн заалт | Хэрэгжилтийн талаархи мэдээлэл |
|---|---|---|
| 1. | Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж үзэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэн, ажиллаж байна.<br>Аймгийн Засаг дарга нарын шууд хариуцан гүйцэтгэх манай аймагт холбогдох 149 арга хэмжээний заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласнаар 2009 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 82.4, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 79.2 хувь хэрэгжиж байна.<br><br>Хэрэгжиж байна 90% |
| 2. | Засаг төрийн төлөөлөгчийн хувьд батламжаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн хууль ёсыг чандлан сахиж Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг удирдлага болгон ажиллана. | Аймгийн Засаг дарга 2009 онд Монгол улсын хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд нийт 478 захирамжийг батлан гаргаад байна.<br>Монгол Улсын Засгийн газрын хууль тогтоомжийг хяналтанд авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа 140 тогтоол шийдвэрийн 170 заалт 2009 оны байдлаар 88,1 хувийн хэрэгжилттэй байна.<br><br>Хэрэгжиж байна 90% |
| 3. | Нутгийн захиргааны байгууллагыг ажил эрхлэх ур чадвар, мэдлэг боловсрол, туршлагатай, мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэн, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар үйлчилнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 67 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс /Хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай/, Хууль зүйн хэлтэс /Архивын албатай/, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Цэргийн штабтайгаар шинэчлэн зохион байгуулж, Тамгын газрын даргын тушаалаар батлан үйл ажиллагаа явуулж байна.<br>Бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын дэргэдэх зарим газар, хэлтсийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт хийж, Ерөнхий менежерүүдийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж бүрэн томилоод байна.<br>Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төрийн захиргааны олон улсын институт /SIPU internial/-тай хамтран хэрэгжүүлж буй “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 5 удаагийн үндсэн сургалт зохион байгуулагдан 100 ерөнхий менежер манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамрагдлаа. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Ёс зүйт манлайлал” |

| | | |
|---|---|---|
| | | сургалтад 20 ерөнхий менежер, “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Үйлчилдэг удирдлага” сэдэвт сургалтад 35 ерөнхий менежерүүд тус тус хамрагдлаа. Манлайлалын мастер сургагчаар 3 төрийн албан хаагчийг бэлтгэн сургалтыг зохион байгуулж байна.<br>Хэрэгжиж байна 90% |
| 4. | Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг байнга сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авилгал, хээл хахуультай тууштай тэмцэж ажиллана. | Аймгийн төсөвт 32,5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 107,5 хувь байна. Өнгөрсөн оноос орон нутгийн төсвийн орлого 4,4 хувиар нэмэгдлээ.<br>Тайлант онд татварын орлого 7,2 хувиар, татварын бус орлого 56,3 хувиар давж биеллээ. Аймгийн төсвөөс улсын төсөвт 26,2 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу тэгшитгэв.<br>Улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын сонгон шалгаруулалтыг ил тод, шударга явуулах зорилгоор гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог тухай бүр шинэчлэн байгуулж тендерийн тухай Сангийн яамны веб сайт, төвийн болон, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж, нээлттэй ил тод зохион явууллаа. Хөрөнгө оруулалтын ажлыг үр ашигтай, чанартай хийлгэх зорилгоор Сангийн сайдын 58-р тушаалын дагуу урьдчилгааг 30 хүртэл хувиар олгож ажил дууссан үед техникийн болон улсын комисс ажлыг бүрэн хүлээн авсны дараа актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг эрх нээн олгож, явцын хяналтыг сайжруулан олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна.<br>Нийт сонгон шалгаруулалтын ажлын үр дүнгээр Ногоон байгууламжийн хайсны батлагдсан зардлаас 12.1 сая, дээврийн засварын ажлаас 6.5 сая, Сүхбаатарын өргөн чөлөөний авто замын гэрэлтүүлгийн ажлаас 4.5 сая, нийтдээ 24.5 сая төгрөгийн хэмнэлт гарлаа.<br>Хэрэгжиж байна 90% |
| 5. | Аймгийн бодит эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэндийн зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана. | □□□□□□□ □□□□□ □□□□□ □□□□□□□ ө□ө□□□□□ □□□□□□□□ □□□□□□□□ □□□□, □□□□□□□□□, □□үү□ □□□□□□□ □□□□□ □□□□□□□□ □□□□□□□□ □□□□ □ө□□□□□□ □□□□□□ □□□□□□□ □□□□□. □□□□□□□□□:<br><u>□□□□□□□□□□□ □□□□□□□</u><br>Улсын төсвөөс Их залуу багт 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга барихад 450.0 сая, “Наран”, “Эрдэнэт” цогцолбор сургуулийн хичээлийн I, II байрны дээврийн засварт 45.0 сая, Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжүүлж буй “Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр II”-ийн хүрээнд “Эрдэнэт” цогцолбор сургуулийн хичээлийн I байрыг 184.0 сая, орон нутгийн төсвөөс 16-р цэцэрлэгийг 18.0 сая, 19-р цэцэрлэгийг 4.9 сая, 17-р цэцэрлэгийг 13.0 сая, “Орхон” цогцолбор сургуулийн II байрыг 15.1 сая, Дэлхийн банкны “Үр дүнд түргэн хүрэх санаачлага” төслөөс Жаргалант сумын сургуулийн дотуур байрыг 94.0 сая, 17 дугаар сургуулийн уурын зуухыг 30.0 сая төгрөгөөр засварлан нийт **854.0 сая** төгрөгийг их засвар, барилга угсралтанд зарцуулсан байна.<br>“Тогтвортой амьжиргаа II” төслийн хүрээнд 11 цэцэрлэгт 47.3 сая төгрөгийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, Жаргалант сумын 3-р цэцэрлэгт 4.3 сая, 22-р цэцэрлэгт 2.8 сая |

| | | |
|---|---|---|
| | | өөрсдийн авьяас чадвараа хөгжүүлж, хүүхэд, өсвөр үеийнхний дунд соёл хүмүүжлийн 157 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 118024 хүүхэд хамрагдлаа. Үүнээс урлагийн 27, спортын 12, уулзалт, ярилцлага 25, аян өдөрлөг 17, судалгаа 6, сургалт 21, бусад 67 арга хэмжээг зохион байгууллаа.<br>Оюутны унаа тээврийн асуудлыг хөнгөвчлөх чиглэлээр төрийн захиргаа, зорчигч тээврийн байгууллага, Оюутны холбооны гурвалсан судалгааг үндэслэн туршилтын журмаар ердийн тарифаас 50 төгрөгийн хөнгөлөлттэйгээр 2 маршрутад автобус явуулж байгаа ба шилдэг 3 оюутанд сургалтын тэтгэлэг олгож байна.<br>2009 онд орон нутагтаа 201 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, 40100 хүн хамруулсны зэрэгцээ 31 төрлийн секц дугуйланд 7030 хүн хичээллэж байна.<br>Хэрэгжиж байна 90% |
| 6. | Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга, хариуцлагыг сайжруулж өндөр шаардлагатай ажиллана. | Архидан согтуурахтай тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор жил бүр аттестатчилал явуулж байгаа бөгөөд “Захирамж”, “Согтуурал” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион байгуулав.<br>2009 онд 393 цэг салбарт аттестатчлал явуулж, аймгийн Засаг даргын захирамжаар 73 цэг салбарын үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, 15 цэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлэв. Монгол улсын “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлыг төрөл бүрийн хэлбэрээр иргэдэд сурталчлан 23 удаа уулзалт өдөрлөг зохион байгуулж, 2304 хүн хамруулсан ба, энэ чиглэлээр 60 арга хэмжээ зохион байгуулж, архины хор холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр 84 удаа сурталчиллаа.Төвийн болон орон нутгийн сургалтуудад энэ чиглэлээр хяналт тавьж ажилладаг байгууллагуудын албан хаагч нарыг хамруулан ажиллав.<br>Аймгийн хэмжээнд 2009 оны 02-р сараас эхлэн Хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж эхлэн 34 албан хаагчтайгаар 6 автомашинаар үүрэг гүйцэтгэж ирлээ. Хөдөлгөөнт эргүүлийн 6 чиглэлд иргэд, байгууллагаас ирсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллээр хэргийн газарт 2-4 минутын хугацаанд очиж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэж байна.<br>Эдгээр арга хэмжээний үр дүнд аймгийн хэмжээнд 2009 оны байдлаар 98 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23,4 хувиар буурсан байна. Мөн гудамж талбайд голлон үйлдэгддэг булаалт, дээрэм, танхайн хэргүүд буурлаа.<br>Хэрэгжиж байна 90% |
| 7. | Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Шадар сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг | Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Шадар сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тухай бүр тайлагнан ажиллаж байна.<br>Аймаг, орон нутгийн цаг үеийн байдлын мэдээ, мэдээллийг сар бүр зохих хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж хэвшсэн болно. |

| | | |
|---|---|---|
| | туслалцааг авч ажиллана. | Хэрэгжиж байна 90% |
| 8. | Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авилгал, хээл хахуульд оролцсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан зэрэг тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл, хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаас чөлөөгдөх нь улс төрийн намын хаацайлалыг эрэлхийлэх шалтгаан болохгүй. | Тайлангийн хугацаанд ажил үүргээ хэвийн гүйцэтгэж, ямар нэг алдаа дутагдал, зөрчил гаргахгүй ажилласан болно.<br><br>Биелсэн 100% |
| 9. | Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг хагас жил тутам Засгийн газарт тайлагнана. | Засгийн газрын 2010 оны 11 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 2009 оны энэхүү батламжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг үнэлэн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт ЗГХЭГ-т хүргүүлж байна.<br><br>Биелсэн 100% |

БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д. ОЮУНБАТ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТЗУХ-ИЙН
ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА Ж. БАТ-ЭРДЭНЭ